



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/124

Ховд

Тооллогын комисс томилох тухай

Монгол Улсын “Төрийн болон албаны нууцын тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалт, “Батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журам”-ын 2 дугаар бүлгийн 2.1.4, 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт ашиглагдаж байгаа онц чухал-маш нууц, маш-нууц, нууц ном материал, данс бүртгэлийн 2021 оны бүтэн жилийн тооллогыг 12 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд зохион байгуулж явуулсугай.

2. Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Б.Ганхуяг - Цэргийн штабын дарга, хурандаа

Гишүүд: Д.Одгэрэл - Дайчилгааны офицер, дэд хурандаа

Д.Тамир - Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер, хошууч

3. Онц чухал-маш нууц, маш-нууц, нууц ном материал, данс бүртгэлийг нэг бүрчлэн хуудас бүрээр нь тоолон, дүнг 12 дугаар сарын 03 -ны дотор танилцуулан, актыг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлэхийг комиссын дарга /хурандаа Б.Ганхуягт /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД